



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 26 өдөр

Дугаар A/62

Улаанбаатар хот

“Богдхан уулын трейл 2019” олон
улсын гүйлтийн тэмцээн зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/746 тоот захирамж, газрын дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хотод тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгож, тэдний сонирхлыг татах зорилгоор “Богдхан уулын трейл 2019” олон улсын гүйлтийн тэмцээнийг 2019 оны 07 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т үүрэг болгосугай.

2. “Богдхан уулын трейл 2019” олон улсын гүйлтийн тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Наадмыг зохион байгуулахад шаардагдах төсөв болох 7 000 000 /долоон сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТЦУХ

• 1150500287

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 07
сарын 26 өдрийн А/62 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

5234025 СБТ-8936 1118203502

Ажлын хэсгийн ахлагч:

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
дарга В.Батчимэг

Гишүүд:

Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч М.Болортуяа

Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн
маркетинг хариуцсан мэргэжилтэн
Э.Оргилцэцэг

Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
хөгжлийн бодлого хариуцсан
мэргэжилтэн Н.Алтанзаяа

Нарийн бичгийн дарга:

Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
соёлын аялал жуулчлал, эвент
хариуцсан мэргэжилтэн Б.Үржинханд

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 07
сарын 26 өдрийн А/62 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284125 СБТ-48976 1118263502

“БОГДХАН УУЛЫН ТРЕЙЛ 2019” ОЛОН УЛСЫН ГҮЙЛТИЙН
ТЭМЦЭЭНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын төрөл		Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз түрээс /5х4 хэмжээтэй, 2/		Багц	2 100 000	2 100 000
2	Асар майхан түрээс /4х4 м хэмжээтэй, 1 өдөр/		10	100 000	1 000 000
3	Медаль /64км/		200	8 000	1 600 000
4	Зөөврийн био 00 түрээслэх		4	250 000	1 000 000
5	64 км зайн эхний гурван байрны шагнал	1-р байр /эр,эм/	2	300 000	600 000
		2-р байр /эр,эм/	2	200 000	400 000
		3-р байр /эр,эм/	2	150 000	300 000
Нийт					7 000 000

-ooOoo-